



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 01/01

Жавхлант

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 05 сарын 28 ны өдрийн хуралдааны "2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/12 дугаар тогтоолын 2,3,4 –р хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бэлчээрийн газрын хөрсийг сэргээх, бэлчээрийг сайжруулах, доройтсон бэлчээрийг өнжөөн сэлгэж уламжлалт аргаар сэргээх зорилгоор 2025 оны 05 сарын 30-ны өдрөөс 2025 оны 09 сарын 20-ныг хүртэл малын хөлөөс түр хугацаагаар чөлөөлсүгэй.

2. Нөхөрлөл бүр баталгаат газар нутгийн хүрээнд уламжлалт аргаар бэлчээр чөлөөлж, сэлгэн нүүх ажлыг зохион байгуулсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, тогтоосон хугацаанд бэлчээрийг малын хөлөөс түр хугацаагаар чөлөөлөх ажлыг чанартай зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, нөхөрлөлийн ахлагч, тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч, Идэвхтэн байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (П.Эрдэнэчимэг), Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан (Н.Отгонбат), Газрын даамал (Ш.Аюушсүрэн) багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН

Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 110 тоот захирамжийн I хавсралт

